## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 01 сарын 04 өдөр Дугаар А-1/А-1 Эрдэнэт

### Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх тухай

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн №А/807, 216 тоот хамтарсан тушаал, Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.8, 8.2.9, 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, баталгаажуулах, хяналт тавих журам", Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн №А/807, 216 тоот хамтарсан тушаалын хэрэгжилтийг хянах, сайжруулах зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд Нийгмийн халамжийн сангаас байнгын асаргааны тэтгэмж авагч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхөөр зочилж, эрүүл мэндийн нөхцөлийг үнэлэх, шалгуур, үзүүлэлтэд нийцэхгүй, эрүүл мэндийн байдал сайжирсан иргэнийг байнгын асаргаанаас гаргах саналыг БОЭТ-ийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст хүргүүлэхийг тус тус үүрэг болгосугай.
2. Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар батласугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 02 дугаар сарын 15-ны дотор тайлагнахыг Нийгмийн халамжийн хэлтсийн дарга /С.Мөнхцэцэг/, Эрүүл мэндийн газрын Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн /М.Бямбасүрэн/, Сум өрхийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /А.Хонгорзул/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Д.СҮХЭЭ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Ж.ЭРДЭНЭБАТ

ЭМГ, ХХҮГ-ын даргын
2023 оны 01 дүгээр сарын 09 өдрийн
А/01/тоот хамтарсан тушаалын хавсралт №1

# ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН УДИРДАМЖ

2023.01.03 Эрдэнэт

**Нэг.Зорилго**

"Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, баталгаажуулах, хяналт тавих журам", Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн №А/807, 216 тоот хамтарсан тушаалын хэрэгжилтийг хянах, сайжруулах зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд Нийгмийн халамжийн сангаас байнгын асаргааны тэтгэмж авагч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхөөр зочилж, эрүүл мэндийн нөхцөлийг үнэлэх, шалгуур, үзүүлэлтэд нийцэхгүй, эрүүл мэндийн байдал сайжирсан иргэнийг байнгын асаргаанаас гаргах саналыг БОЭТ-ийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст хүргүүлэх

**Хоёр. Шалгалт хийх хугацаа**

Хяналт шалгалтын ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл Баян-Өндөр, Жаргалант сумын холбогдох багуудад зохион байгуулна.

**Гурав. Ажлын хэсэг, бүрэлдэхүүн:**

Ажлын хэсэг нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүн, өрхийн эмч, багийн нийгмийн ажилтан, ХЭХАХСМэргэжилтэн, нийгмийн халамжийн хэлтсийн мэргэжилтнээс бүрдэх ба холбогдох багийн хэсгийн ахлагч нарыг ажилд туслалцуулна.

**Дөрөв. Гүйцэтгэх ажил:**

1. Холбогдох баг хариуцсан ХЭХАХМэргэжилтэнүүд байнгын асаргаатай иргэдийн нэрсийн жагсаалт болон хувийн хэргийг бэлтгэсэн байх, хувийн хэргийн баяжилт, бүртгэлийг хөтөлсөн байх.
2. Ажлын хэсэг нь байнгын асаргааны тэтгэмж авагч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхөөр зочилж, НТХ-ийн 3.1.6 дугаар заалт дахь тодорхойлолт, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үнэлэх шалгуур үзүүлэлттэй нийцэж байгаа эсэхийг хянан, шалгаж, дахин үнэлэх.
3. Шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй, эсвэл эрүүл мэндийн нөхцөл байдал сайжирсан иргэнийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст уламжилж, үйлчилгээг зогсоох.

4. Хариуцсан багийн мэргэжилтэнүүд үйлчилгээ зогсоогдсон иргэдийн мэдээллийг жагсаалтаар гаргаж, хувийн хэргүүдийг архивт хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

**<u>Тав; Шалгалтын мөрөөр авах арга хэмжээ;</u>**

1. Хяналт шалгалтын ажлын талаарх тайланг хуваарийн дагуу томилогдсон ажлын хэсгийн ахлагч тус бүрээр гаргаж, үйлчилгээ зогсоогдсон иргэдийн жагсаалтыг гарган, Тэтгэвэр тэтгэмж хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, үйлчилгээг программд зогсоолгох.
2. Тайлан тус бүрийн дүнг нэгтгэн гаргаж ажлын хэсгийн хуралдаан хийх
3. Хяналт шалгалтын үр дүнгийн талаар байгууллагын удирдлагуудад танилцуулах

Удирдамж боловсруулсан:

Нийгмийн халамжийн хэлтсийн дарга С.Мөнхцэцэг

ЭМГ, ХХҮГ-ын даргын
2023 оны 01 дүгээр сарын 01 өдрийн
А/1/01 тоот хамтарсан тушаалын хавсралт №2

НХС-аас байнгын асаргааны тэтгэмж авагч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөөр зочлон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийх ажлын хэсгийн хуваарь

2023.01.03 Эрдэнэт

| № | Ажлын хэсэг | Багийн нэр | БА-тай ахмад настны тоо | БА-тай ХБИ-ний тоо |
|---|---|---|---|---|
| 1 | **Б.Баярсайхан /99353580/**<br>ХЭХАХСМ<br>ЭХК-ын гишүүн<br>Өрхийн эмч<br>Багийн нийгмийн ажилтан | Зэст | 48 | 17 |
| | | Оюут | 26 | 10 |
| | | Уурхайчин | 41 | 9 |
| | | Уртбулаг | 36 | 17 |
| | | Бүрэнбүст | 20 | 10 **/234/** |
| 2 | **Ө.Дэлгэрмаа /99027881/**<br>ХЭХАХСМ<br>ЭХК-ын гишүүн<br>Өрхийн эмч<br>Багийн нийгмийн ажилтан | Согоот | 42 | 15 |
| | | Дэнж | 63 | 24 |
| | | Эрдэнэ | 56 | 36 **/236/** |
| 3 | **М.Оюунгэрэл /99365501/**<br>ХЭХАХСМ<br>ЭХК-ын гишүүн<br>Өрхийн эмч<br>Багийн нийгмийн ажилтан | Даваат | 50 | 25 |
| | | Рашаант | 63 | 26 |
| | | Булаг | 34 | 15 **/213/** |
| 4 | **А.Жаргалсайхан 99365834**<br>ХЭХАХСМ<br>ЭХК-ын гишүүн<br>Өрхийн эмч<br>Багийн нийгмийн ажилтан | Баянбулаг | 38 | 15 |
| | | Шанд | 30 | 18 |
| | | Уртын гол | 45 | 13 |
| | | Цагаанчулуут | 71 | 17 **/247/** |
| 5 | **О.Нансалмаа /95348030/**<br>ХЭХАХСМ<br>ЭХК-ын гишүүн<br>Өрхийн эмч<br>Багийн нийгмийн ажилтан | Хүрэнбулаг | 41 | 11 |
| | | Наран | 51 | 14 |
| | | Говил | 27 | 8 |
| | | Баянцагаан | 39+4 | 24+2 **/221/** |
| 6 | **С.Мөнхцэцэг /99358319/**<br>ХЭХАХСМ<br>ЭХК-ын гишүүн<br>Өрхийн эмч<br>Багийн нийгмийн ажилтан | Их залуу | 45 | 20 |
| | | Яргуйт | 64 | 26 |
| | | Жаргалант | 44 | 15 **/214/** |
| | **НИЙТ** | | **978** | **387** |